



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Эд хөрөнгө бүртгэж авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 75.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/279 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж" төсөл арга хэмжээний хүрээнд хуваарилагдсан 74,822,820 (далан дөрвөн сая найман зуун хорин хоёр мянга найман зуун хорь) төгрөгийн үнэ бүхий 18 ширхэг хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийх, тайлагнахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д үүрэг болгосугай.

2. Үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд зохих журмын дагуу бүртгэх ажлыг зохион байгуулахыг Өмч хамгаалах байнгын зөвлөл (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн аялал жуулчлалын газрын даргын
2024 оны...10...дугаар сарын...21...-ны өдрийн...
дугаар тушаалын хавсралт

Эд хөрөнгийн жагсаалт

№	Нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Dell Optiplex 7010 i7-13700 16GB 256GB SSD 1TB HDD Суурин компьютер	Ширхэг	15	3,975,000	59,625,000
2	Canon iR C3326i Өнгөт принтер	Ширхэг	1	12,709,180	12,709,180
3	Canon 59380019AA принтер MF264dw Жижиг принтер	Ширхэг	2	1,244,320	2,488,640
	Нийт дүн		18		74,822,820